

# МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

---

№ 18/5

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг өөрчлөх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны энэ удаагийн хуралдаанаар 11 дүгээр сарын ээлжит бус хуралдаанаас хойш эдийн засгийн байдалд гарсан өөрчлөлтүүд болон ирээдүйн төлөв, инфляци, санхүүгийн зах зээл, гадаад тодорхой бус байдал, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлын шинжилгээний үр дүнгийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци 2018 оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 8.1 хувьтай байгаа бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд 9.3 хувьд хүрсний 50 орчим хувийг мах, хатуу түлш, шатахууны үнийн өсөлт бүрдүүлж байгааг МБГ-аас онцлов. Тодруулбал, 1) хатуу түлшний үнэ өмнөх оны мөн үеэс 60 хувиар нэмэгдсэн, 2) махны экспорт сүүлийн саруудад өссөн нь махны эрэлтийг нэмэгдүүлж, улмаар махны үнэ олон жилийн улирлын хандлагаас зөрж өссөн, 3) шатахууны үнэ 10 дугаар сарын сүүлийн долоо хоногт 100 төгрөгөөр нэмэгдсэн нь инфляци тайлант сард нэмэгдэхэд нөлөөлөв. Эдгээр нийлүүлэлтийн шалтгаанаас үүссэн үнийн өсөлтийг хасч тооцвол эрэлтийн шинжтэй инфляцийн дарамт төдийлөн эрчимжээгүйг онцлов. Цаашид цалин болон дотоод эрэлтийн өсөлтөөр дамжин инфляци нэмэгдэхээр байгааг танилцууллаа.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн саруудад нэмэгдсэн нь банкны системээс иргэдэд олгосон хэрэглээний зориулалттай зээлийн өсөлттэй холбоотойг онцлов. Нийт зээлийн өсөлт 11 дүгээр сарын байдлаар 20 орчим хувьд хүрсний 11 нэгж хувийг хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлсэн байна. Бизнесийн зээлийн өсөлт сүүлийн 8 сарын турш нэмэгдэх хандлагатай байна. Бизнесийн зээлийн өсөлтийн дийлэнхийг худалдаа, уул уурхай, барилгын салбар бүрдүүлж байна. Түүнчлэн валютын ханшийн хэлбэлзэлтэй холбоотойгоор сүүлийн 2 сарын хугацаанд зээлийн долларжилт буурч байгааг дурьдав.

Зах зээл дэх гадаад валютын эрэлт нэмэгдэж, валютын ханшийн хэлбэлзэл өссөн энэ үед МБГ-аас гадаад валютын нөөцийн хүрэлцээтэй байдал болон

зохистой түвшинг тодорхойлох шинжилгээний үр дүнг танилцууллаа. ОУВС-гийн АРА метрик аргачлалын дагуу валютын нөөцийн зохистой түвшинг М2 мөнгөний нийлүүлэлтийн 5 хувь, экспортын орлогын 5 хувь, богино хугацаат өрийн 30 хувь, бусад өр төлбөрийн 15 хувийн нийлбэртэй тэнцүү байхаар тооцсон. Гадаад валютын нөөц өнөөгийн байдлаар зохистой түвшний 60 хувьтай тэнцэж байгааг онцлов.

Худалдааны тэнцэл эхний 11 сарын байдлаар ашигтай гарсан бөгөөд энэ нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлж байна. Тайлант сарын гүйцэтгэлээр шатахууны импорт хүлээлтээс давж нэмэгдэв. Харин экспорт төсөөллөөс өндөр гүйцэтгэлтэй байсан нь хилийн боомтоор нүүрс нэвтрүүлэх чадвар сайжирсантай холбоотой байв.

Танилцуулгын төгсгөлд төсөөллийн тодорхой бус байдлыг хэлэлцэж, гадаад эдийн засгийн орчны тодорхойгүй байдал хэвээр байгааг онцоллоо. Хэдийгээр АНУ 2019 оноос эхлэн БНХАУ-ын бүтээгдэхүүнд 25 хувийн тариф ноогдуулах арга хэмжээг 90 хоногийн хугацаатайгаар хойшлуулсан боловч худалдааны зөрчилдөөн цаашид хэрхэн үргэлжлэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн геополитикийн асуудлуудаас шалтгаалан нефтийн бүтээгдэхүүний үнэд гарах өөрчлөлт, БНХАУ-ын Засгийн газраас дотоод эдийн засагт баримтлах бодлого, нүүрсний экспортын хилийн хязгаарлалт цаашид бүрэн арилах эсэх нь гадаад тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байна. Харин дотоод эдийн засагт улс төрийн тогтворгүй байдал, мега төслүүдийн хөрөнгө оруулалт, хэрэглээний зээлийн өсөлт, зээлийн чанар болон хатуу түлш, мах, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ цаашид хэрхэн өөрчлөгдөх зэрэг нь тодорхой бус байдлыг бий болгож байна.

Суурь төсөөллөөр 2019 онд инфляци зорилтот түвшний орчимд буюу 8.4 хувь, эдийн засгийн өсөлт 6.6 хувьд хүлээгдэж байна. Эдийн засгийн идэвхжил болон цалингийн өсөлтийг дагаад эрэлтийн шалтгаантай инфляци нэмэгдэж, цалин болон зарим төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа хэдий ч нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт саарч, шатахууны үнэ харьцангуй тогтвортой байх төлөвтэй байгааг танилцуулав.

МБГ-ын зүгээс бодлогын хүүг хэвээр хадгалах санал гаргасныг МБХ-ны гишүүд шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнүүлэв.

МБХ-ны гишүүдийн хувьд нийлүүлэлтийн шалтгаантай бий болсон инфляцийг бууруулах зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлэх нь үр дүнтэй бодлогын арга хэмжээ биш гэж үзэв. Гэхдээ сүүлийн саруудад үүссэн валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан инфляци ирэх онд нэмэгдэх эрсдэлтэй

байгааг онцлов. Мөн хэрэглээний зээлийн өсөлтийг тогтворжуулах болон банкны системийн долларжилтыг бууруулах зорилготой макро зохистой бодлогын арга хэмжээ 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжих тул энэ удаад бодлогын хүүг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзлээ.

Зарим гишүүд бодлогын шийдвэрийг гаргахад анхаарах дараах хүчин зүйлс байгааг дурьдав. Үүнд, төсвийн зардал сонгуулийн жилтэй холбоотойгоор ирэх онд нэмэгдэхээр байгаа нь эрэлтийн шинжтэй инфляцийн дарамтыг өсгөх эрсдэлтэй байна. Мөн ирэх жилүүдэд гадаад өрийн үндсэн төлбөрүүд хүлээгдэж байна. Энэ нөхцөлд экспортын орлого төдийлөн нэмэгдэхгүй, импортын өсөлт өндөр хэвээр байгаа нь төлбөрийн тэнцлийн дарамтыг даамжруулж болзошгүйг сануулав.

Мөнгөний бодлогын хорооны гишүүд бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах саналыг 100% дэмжлээ.

Хурлын эцэст Монголбанкнаас мөнгөний бодлогын чиглэлээр 2018 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үндэслэл, үр дүнгийн талаар тусгасан МБХ-ны нээлттэй захидлын талаар хэлэлцэж, олон нийтэд танилцуулахыг дэмжив.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны МБХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргав. Бодлогын хүүний шийдвэрийг 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.